



ШҮҮХИЙН СУРГАЛТ,  
СУДАЛГАА,  
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ЗЭЭЛИЙН  
ШИМТГЭЛТЭЙ  
ХОЛБООТОЙ МАРГААНЫ  
СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2022/09/24

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ  
2022.10.21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
УДИРТГАЛ .....	4
НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛИЙН ШИМТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН.....	5
Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээний талаар үндсэн ойлголт.....	5
2. Банк, эрх бүхий этгээдээс олгож буй зээлийн харилцаанд хэрэглэгдэж буй “зээлийн шимтгэл”-ийн нөхцөлийн үүсэл, дотоодын эрх зүйн зохицуулалт .....	6
Хоёр. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА .....	11
1. Япон Улс.....	11
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	13
3. Бүгд Найрамдах Энэтхэг Улс .....	14
4. Канад Улс.....	15
5. Австралийн Холбооны Улс.....	16
ДҮГНЭЛТ.....	20

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АШШ</b>	Анхан шатны шүүх
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>БНЭУ</b>	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
<b>ДЗШШ</b>	Давж заалдах шатны шүүх
<b>УДШ</b>	Улсын дээд шүүх
<b>ШӨХТГ</b>	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
<b>ШССМХ</b>	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

## УДИРТГАЛ

### Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд тусгагдсан банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээлдэгч нартай байгуулж буй зээлийн гэрээ, түүнд тусгагдаж буй “зээлийн шимтгэл”-ийн зохицуулалт нь хуульд нийцсэн эсэх болон “зээлийн шимтгэл”-ийн зохицуулалт хүчин төгөлдөр эсэх, тухайн зохицуулалтын үүсэл, үндэслэлийн талаар дотоодын эрх зүйн эх сурвалж болох хууль тогтоомж, Монгол банкны Ерөнхийлөгчийн баталсан журмаас судлахын зэрэгцээ Монгол Улсын арилжааны банкнаас зээлдэгч нартай байгуулж буй гэрээнд тусгагдсан “зээлийн шимтгэл”-ийн зохицуулалт нь гэрээний стандарт нөхцөлд хамаарах эсэх тухай авч үзэх болно.

Мөн бусад гадаад улсад банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээг хэрхэн байгуулдаг, “зээлийн шимтгэл”-ийн нөхцөл тусгагддаг эсэх, тусгагддаг бол түүний хувь хэмжээг хэрхэн тогтоодог талаар харьцуулан судалж дүгнэнэ.

### Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Монголбанкны зүгээс батлан хэрэгжүүлж байсан журам, ижил төстэй маргааныг шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн талаар шүүхийн шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн судалж, харьцуулсан судалгааны хүрээнд Япон Улс, БНХАУ, БНЭУ, Канад Улс, Австралийн Холбооны Улсыг хамруулан эрх зүйн зохицуулалт, төсөөтэй маргаан гарсан тохиолдолд түүнийг шүүхээс хэрхэн хянан шийдвэрлэж байсан талаар судалсан болно.

### Судалгааны арга зүй

Судалгааг хийж гүйцэтгэхдээ түүхчлэн судлах, харьцуулан судлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

### Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Монгол Улсын зээлийн шимтгэлтэй холбогдох эрх зүйн орчин, Харьцуулсан судалгаа, дүгнэлт, эх сурвалж, хавсралт хэсгээс бүрдэнэ.

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛИЙН ШИМТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн гэрээний талаар үндсэн ойлголт

Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичигт зээлийн гэрээ гэдгийг “Зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг хүлээсэн иргэний эрх зүйн хэлэлцээрийг хэлнэ”<sup>1</sup> хэмээн тодорхойлсон байна. Мөн иргэний эрх зүйн онолын сурах бичигт зээлийн харилцааг “Зээл хэмээх үгийн утга нь санхүүгийн зорилгоор мөнгө шилжүүлэх үйл явцыг илэрхийлэх бол зээлийн гэрээ нь бодитоор хэдэн төгрөг олгосноос үл хамааран консенсуал буюу зөвшилцлийн үндсэн дээр байгуулагдах тохиролцоог илтгэдэг, тиймээс зээлийн гэрээний гол агуулга нь тодорхой капитал, түүнд шингэсэн зах зээлийн үнийг ашиглах боломж олгоход чиглэдэг”<sup>2</sup> хэмээн тодорхойлжээ.

Зээлийн гэрээний зохицуулалтыг “Иргэд хоорондын зээл”, “Банк, эрх бүхий этгээдээс олгох зээл” гэсэн төрлөөр Иргэний хуулийн §§281-286 болон §§451-453 дугаар зүйлүүдэд хуваан зохицуулсан.<sup>3</sup> Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зээлийн гэрээг “Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.” хэмээн хуульчилж өгснөөс гадна Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг нь дээрх ерөнхий зээлийн гэрээний харилцааг Банк, эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох харилцаанд илүү дэлгэрэнгүй байдлаар “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ”. хэмээн хуульчилсан байна.

Банк, эрх бүхий этгээдээс зээл олгох харилцааны процессын нэг хэсэгт үндсэн зээл, зээлийн хүүг төлүүлэх, зээлийн шимтгэл тооцон суутгах үйл ажиллагаа хамаарна. Иргэний хуулийн 450 дугаар зүйлийн 450.1 зааснаар банк нь төлбөр хүлээн авах үүрэг хүлээх тул энд төлбөр тооцооны гэрээний дагуу угаасаа үүсэх төлбөр тооцоог хүлээн авч, харилцагчийн дансанд байршуулах үүрэгтэй.<sup>4</sup> Зээлийн зардалд үйлчилгээтэй холбогдон гардаг төрөл бүрийн шимтгэл хураамжууд ордог ба үүнд өргөдлийн хураамж<sup>5</sup>, зээл

<sup>1</sup> Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он, 175 дахь тал.

<sup>2</sup> Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2021 он, 110 дахь тал.

<sup>3</sup> Мөн тэнд. Эшлэл 3. 121 дахь тал.

<sup>4</sup> Ё.Кают, Иргэний хуулийн тайлбар, 885 дахь тал.

<sup>5</sup> Анх зээлийн хүсэлт гаргахад 1 удаа төлдөг 5000-15000 төгрөгийн хураамжийг хэлэх ба зориулалтын хувьд зээлийн өргөдөл гаргаж буй хүн бүр зээлдэгч болдоггүй тул банк өөрийн үйл ажиллагааны зардлыг энэ хураамжид шингээж өгсөн байдаг.

олголтын шимтгэл<sup>6</sup>, нотариатын зардал<sup>7</sup> багтах ба “шимтгэл”-ийг тодорхой үнийн дүнгээс хувиар тооцдог бол “хураамж” нь тогтмол дүнгээр илэрхийлэгдсэн байдаг<sup>8</sup> байна.

Манай улсын Банк, эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох үйл ажиллагаанд үндсэн зээл болон зээлийн хүүгээс гадна зээлийн шимтгэл суутгаж авах явдал нь нэгэнт жишиг болж тогтсон байна гэж үзлээ<sup>9</sup>. Тухайлбал банк тухайн харилцагчийн зүгээс гаргасан “зээл авах тухай хүсэлт”-д заасан хэмжээний мөнгөн дүнгээс тодорхой хувийг суутгаж (зээлийн хүү, шимтгэлийг хасан тооцож)<sup>10</sup> зээлийн дансанд байршуулдаг. Энэхүү үйл ажиллагаанаас үүдэн “зээлийн гэрээ байгуулах хүсэлт өгсөн хэмжээгээр зээлийг олгосонгүй, зээлийг дутуу олгож иргэдийг хохироосон, ингэснээр банк Иргэний хуулийн 451 дүгээр зүйлд заасан үүргээ зөрчсөн” гэсэн агуулга бүхий маргаан олноор гарах болжээ (ихэнх тохиолдолд сөрөг нэхэмжлэлийн шаардлагад тусгагддаг).

## **2. Банк, эрх бүхий этгээдээс олгож буй зээлийн харилцаанд хэрэглэгдэж буй “зээлийн шимтгэл”-ийн нөхцөлийн үүсэл, дотоодын эрх зүйн зохицуулалт**

2014 онд ШӨХТГ-аас нэр бүхий 13 банканд зээлийн шимтгэл болон хураамжийн асуудал нь хууль зөрчиж байгаа тул зогсоох албан шаардлагыг хүргүүлж<sup>11</sup> байжээ. Тухайн үед банкнууд зээлийн шимтгэлийг зээл олгоход гарч буй зардал хэмээн тайлбарлаж буй боловч зээл олгоход гарах зардалтай харьцуулахад өндөр тогтоосон, гэрээний харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал алдагдсан гээд холбогдох хуулиудын хэд хэдэн заалтыг зөрчиж байгааг ШӨХТГ-аас мэдээлж байсан<sup>12</sup>. Энэ талаар Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг 2017 оноос 2021 оны хооронд шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн судлахад ямар нэг илэрц байгаагүй болно.

Судалгааны хүрээнд үүссэн маргааны үндэслэл болж буй банк, эрх бүхий этгээдтэй байгуулсан зээлийн гэрээ нь 2017 оны 3 дугаар сарын 10-ны өдөр байгуулагдсан. Энэхүү зээлийн гэрээ байгуулагдах үед 1995 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль хэрэгжиж байсан ба тус хуулийг 2021 оны 05 дугаар сарын 21-ны өдөр шинэчлэн найруулж, хүчингүй болсонд тооцсон.

<sup>6</sup> Зээлийн шийдвэр гарсны дараа зээл олгоход 1 удаа төлдөг зээлийн дүнгийн 0.5-1%-тай тэнцэх хураамж. Зориулалтын хувьд зээл олгосны дараа зээлийг ашиглах явцад банкнаас хийж буй зээлийн хяналт, зөвлөгөө мэдээллээр хангах, хамтын ажиллагаатай холбоотой зардал үүнд багтдаг.

<sup>7</sup> Зээлийн шийдвэр гарсны дараа зээлийн гэрээг баталгаажуулах зардал бөгөөд гэрээний үнийн дүнгээс хамаарч үнэлгээ нь харилцан адилгүй. Зориулалтын хувьд зээлийн гэрээг эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болгохтой холбоотой, гэрээ баталгаажуулах зардал юм.

<sup>8</sup> Монголбанкнаас гаргасан “Зээл” гарын авлага. 13 дахь тал. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/07.pdf> (Сүүлд үзсэн: 2022.10.13).

<sup>9</sup> Монголын Банкны Холбооны Ерөнхийлөгч Б.Мэдрээ “Дэлхийн ихэнх улсуудад зээлийн шимтгэл 1 хувь байна. Түүнээс дээш нь ч бий. Зээлийн шимтгэлийг зээл олгосны дараа харилцагчаас авдаг. Банк, санхүүгийн академаас зээлийн шимтгэлийн харьцуулсан судалгааг хийсэн. Манай улсад арилцааны банкуудын хэрэглээний зээлийн дундаж шимтгэл 0.75 хувьтай байна.” гэж 2022 оны 9 дүгээр сарын 6-ны дөөр өгсөн ярилцлагадаа дурдаж байжээ. <https://ikon.mn/n/2nra> (Сүүлд үзсэн: 2022.10.20).

<sup>10</sup> Монголбанкнаас гаргасан “Зээл” гарын авлага. 13 дахь тал. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/07.pdf> (Сүүлд үзсэн: 2022.10.13).

<sup>11</sup> <https://gogo.mn/r/l07n8> (Сүүлд үзсэн: 2022.10.17).

<sup>12</sup> Мөн тэнд. Эшлэл 11.

Дээрх хоёр хуулийн холбогдох зохицуулалтыг харьцуулбал:

1995 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	2021 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
2.3.Монголбанк үндэсний <b>төлбөрийн системийг удирдан зохион байгуулж, зохицуулж, хяналт тавих</b> бөгөөд түүнд холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.	6.5. <b>Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчаас зөвхөн гэрээнд тусгасан шимтгэл, хураамжийг төлүүлэх</b> бөгөөд өөрийн үзүүлсэн нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй.
	6.6.Банк, эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний <b>шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох</b> бөгөөд үүнд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо <b>хяналт тавина</b> .
	6.7. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо өөрийн хянан зохицуулах чиг үүргийн хүрээнд банк, эрх бүхий хуулийн этгээдээс тогтоосон бүтээгдэхүүн, үйлчилгээний <b>шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг бууруулахыг санал болгох</b> , саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн <b>шимтгэл, хураамжийн хувь, хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох</b> бөгөөд энэ тухайгаа нийтэд мэдээлэх эрхтэй байна.
21 дүгээр зүйл.Зээл олгох ажиллагаа 1.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон <b>бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлнэ</b> .	19.2.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлэх үүрэгтэй.
21.2.Зээлдүүлэгч нь хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар <b>зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан</b> зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно.	19.3.Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр түүнд зээлийн данс нээж, зээл олгоно.
	19.10. <b>Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Монголбанк</b> , эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо <b>баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина</b> .
	19.15. <b>Зээлдүүлэгч анх зээл олгохдоо зээлдэгчээр зээлийн хүүг урьдчилан төлүүлэхийг хориглоно</b> .

Дээрхээс үзвэл, 1995 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд “зээлийн шимтгэл”-тэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй байсан бол 2021 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар “шимтгэл”-тэй холбоотой зохицуулалтыг илүү дэлгэрэнгүй, ойлгомжтой, нарийвчилсан, уян хатан байж болохуйц байдлаар хуульчилжээ. Тухайлбал: банк нь харилцагчаас зөвхөн гэрээнд заасан хэмжээний шимтгэл төлүүлэх эрхтэй, энэхүү эрхийнхээ хүрээнд шимтгэлийн хэмжээг үндэслэлтэй тогтоох үүрэгтэй ба үүнд Монголбанк хяналт тавьж ажиллах, хэрэв арилжааны банкны тогтоосон зээлийн шимтгэлийн хэмжээ үндэслэлгүй, хэт өндөр байх тохиолдолд

Монголбанк бууруулах санал хүргүүлэх, цаашилбал зээлийн шимтгэлийн хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох эрх бүхий байна г.м.

Түүнчлэн 1996 оны Төв Банк/Монголбанк/-ны тухай хууль болон 2010 оны Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-д зээлийн шимтгэлийн талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байлаа.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталжээ. Тус журмын 9 дүгээр зүйлд зээлийн шимтгэлийн талаар дараах байдлаар зохицуулсан байна<sup>13</sup>:

<p>9.1. Ипотекийн зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс дараахь зардлыг шингээсэн шимтгэлийг зээлдүүлэгч зээлдэгчээр төлүүлэх бөгөөд энэ нь нийт зээлийн дүнгийн 1 хувиас хэтрэхгүй байна. Үүнд:</p> <p>9.1.1. Зээл үүсгэх харилцаа;</p> <p>9.1.2. Зээлийн өргөдөл;</p> <p>9.1.3. Баримт бичгийн судалгаа хийх, шийдвэр гаргах;</p> <p>9.1.4. Барьцаа хөрөнгийн үнэлгээ, тайлан;</p> <p>9.1.5. Зээлийн түүхийн судалгаа;</p> <p>9.1.6. Шуудан, холбоо;</p> <p>9.1.7. Нэмэлт судалгаа, хяналт, шалгалт.</p> <p>9.1.8. Хугацаа сунгасны шимтгэл.</p>
--

Дээрх 2008 онд батлагдсан журмын зохицуулалт нь ипотекийн зээлийн харилцаанд банкнаас олгох зээлийн шимтгэлийг 1 хувиар тогтоох үндэслэл болсон байна гэж үзэх үндэслэлтэй.

Мөн банкнаас олгох зээлийн харилцаанд үйлчлэх Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/236 дугаартай “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/203 дугаартай “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын зохицуулалтыг харьцуулан үзвэл:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13 өдрийн А/236 дугаартай Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 07 дугаар сарын 23 өдрийн А/203 дугаартай Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам
1.3.17 “Шимтгэл, хураамж” гэж банкнаас тогтоож, харилцагчаар төлүүлж буй үнийн дүнгийн тодорхой хувиар илэрхийлсэн хэмжээг, эсхүл тогтмол тогтоосон дүнг.	1.3.17 “Шимтгэл” гэж санхүүгийн үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилгоор банкнаас тогтоож, харилцагчаар төлүүлж буй үнийн дүнгийн тодорхой хувийг.
<p><b>3.2 Зээлийн бүтээгдэхүүний шимтгэл, хураамж:</b></p> <p>3.2.1 <b>Зээлдэгчээс авах шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг банк тогтооно.</b> Зээлдэгчийн оршин байгаа газар, үндэс угсаа, шашин шүтлэг, нийгмийн</p>	<p>Дөрөв. Шимтгэл, хураамж</p> <p>4.1 <b>Харилцагчаас авах шимтгэл, хураамжийн төрөл, хэмжээг банк тогтооно.</b></p> <p>4.2 Банк харилцагчаас авах шимтгэл, хураамжийг зээл, хадгаламжийн <b>гэрээнд заавал тусгана.</b></p>

<sup>13</sup> Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралт. Цахим холбоос: <https://www.mongolbank.mn/documents/regulation/money/bankipotek.pdf> (Сүүлд үзсэн: 2022.10.18).

<p>байдлаас хамааран ялгаатай шимтгэл, хураамж тогтоохыг хориглоно;</p> <p>3.2.2 Банк зээлдэгчээс авах шимтгэл, хураамж болон цаашид авч болзошгүй шимтгэл, хураамжийг <b>зээлийн гэрээнд заавал тусгана;</b></p> <p>3.2.3 Банк зээлийн гэрээнд тусгаагүй шимтгэл, хураамжийг зээлдэгчээс шууд болон шууд бусаар <b>төлүүлэхийг хориглоно.</b></p>	<p>4.3 Зээл, хадгаламжийн гэрээнд тусгаагүй шимтгэл, хураамжийг харилцагчаас шууд болон шууд бусаар <b>төлүүлэхийг хориглоно.</b></p> <p>4.4 Банкны шимтгэл, хураамжийн хэмжээ нэмэгдсэн нь өмнө байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.</p> <p>4.5 Төгрөгөөр олгох, олгосон зээлийн шимтгэл, хураамжийг гадаад валютаар төлүүлэхийг хориглоно.</p>
--	--

Дээрхээс ажиглавал, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам” батлагдсанаас хойш Монголбанкнаас арилжааны банкнуудад зээлийн гэрээнд тусгаж харилцагч буюу зээлдэгчээс шимтгэл авах эрхийг олгосон, зээлийн шимтгэлийг банк өөрөө тогтоохоор зохицуулсан байна гэж үзэж болохоор байна.

Банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн харилцаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/236 дугаар тушаалаар батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам” үйлчилж байсан ба тус журамд 2015 онд нэмэлт өөрчлөлт орсон. Үүнийг доорх зургаар харуулбал<sup>14</sup>:

<sup>14</sup> Монголбанкны цахим хуудас, [https://www.mongolbank.mn/documents/regulation/20150512\\_A85.pdf](https://www.mongolbank.mn/documents/regulation/20150512_A85.pdf) (Сүүлд үзсэн: 2022.10.14).



МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2015 оны 5 сарын 12 өдөр

Дугаар А-85

Улаанбаатар хот

Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл,  
хураамжийн мэдээллийн ил тод байдлын  
журамд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5, 24 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-236 дугаар тушаалаар батлагдсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-д дор дурдсан өөрчлөлтийг оруулсугай:

1) “1.3.17. “Шимтгэл” гэж банкнаас тогтоож, харилцагчаар төлүүлж буй үнийн дүнгийн тодорхой хувийг;” гэж өөрчлөн найруулсугай.

2) “1.3.18. “Хураамж” гэж банкнаас тогтоож, харилцагчаар төлүүлж буй тогтмол дүнг.” гэж нэмсүгэй.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганбат), Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар)-г тус тус үүрэг болгосугай.



ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ

Иймд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А/236 дугаар журамд 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулж “шимтгэл, хураамж” гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг “шимтгэл”, “хураамж” гэж салган, харилцан ялгамжтай байдлаар зохицуулсан байна.

Түүнчлэн зарим судлаач, хуульчид “Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан журмын шимтгэлтэй холбогдох хэсэг /эрх зүйн хэм хэмжээний акт/ нь хуульд нийцсэн байх шаардлагыг хангаагүй ба арилжааны банк энэхүү журмыг үндэслэн хуулиар зөвшөөрөөгүй үйл ажиллагааг хариу төлбөртэйгөөр эрхэлж зээлдэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчиж байна. Монгол Улсын Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу зээлийн гэрээгээр зээлдэгч нь гагцхүү зээлийг ашигласан хугацаанаас хамааралтай зээлийн хүүг л төлөх үүрэгтэй байдаг. Харин зээлийн шимтгэл нь нэг удаа төлж байгаа, зээлийн мөнгөн хөрөнгийг ашигласан хугацаанаас үл хамааралтай, зээлийн үнийн дүнгээс тодорхой хувиар тооцон авч буй хураамж юм. Иймээс энэхүү хураамж нь дээр дурдсан зээлдэгчийн хуулиар хүлээсэн үүрэг болох хүүтэй хамааралгүй. Энэ тохиолдолд банк зээлийн гэрээ байгуулахаас өмнө өөрт нь бий болж буй зардлаа зээлдэгчээс төлж буй хүүгээс олсон орлогоороо хариуцах ёстой тул зээлийн шимтгэл шаардах эрхгүй.”<sup>15</sup> гэж үздэг.

<sup>15</sup> <http://elbpartners.mn/post/57185> (Сүүлд үзсэн: 2022.10.18).

## ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны ажлын хүрээнд бусад гадаад улсын банк, эрх бүхий этгээдээс харилцагч буюу зээлдэгтэй байгуулдаг зээлийн гэрээнд гэрээний стандарт нөхцөл тусгагддаг эсэх, тухайн улсад зээлийн гэрээний “шимтгэл” гэсэн ойлголт байдаг эсэх, хэрэв байдаг бол энэ нь эрх зүйн зарчимд нийцсэн эсэх, тухайн улсын банкны зээлийн үйл ажиллагаанд зээлийн шимтгэлийг хэрхэн тооцдог, ямар журмаар, эрх бүхий ямар этгээд тогтоодог зэргийг тогтоох зорилгоор Япон Улс, БНХАУ, Канад Улс, Австралийн Холбооны Улсыг сонгон авч дэлгэрэнгүй судаллаа.

Дээрх улсуудыг сонгон авахдаа Дэлхийн банкнаас гаргасан интерактив хүснэгтийн дагуу тухайн улс орнуудыг бүс нутгаар нь, эдийн засгийн орлогын хэмжээгээр нь, мөн тухайн улсын зээлийн хүүгийн ялгаатай байдлуудыг тус тус үндэслэсэн. Өөрөөр хэлбэл, тухайн улсын үндсэн зээл, зээлийн хүү зэрэг нь өндөр эсвэл бага байгаа тохиолдолд хэрхэн шимтгэлийг тооцдог тухайд, мөн дундаас доогуур орлоготой эдийн засагтай, дундаас дээш орлоготой эдийн засагтай, өндөр орлоготой эдийн засагтай орнуудын орлогын хэмжээнээс нь хамааруулан зээлийн шимтгэлийг хэрхэн тооцож байгааг харуулах зорилгоор тус улсуудыг сонгон авсан болно<sup>16</sup>.

Зарим судлаач, хуульч, өмгөөлөгч нарын өгсөн ярилцлагад дурдсанаар “ХБНГУ-ын хувьд 2011 оноос хойш хэд хэдэн шүүхийн шийдвэрүүд гарсан. Энэхүү шийдвэрүүдээр гэрээний стандарт нөхцөлийг зээлдэгчид илэрхий хохиролтой нөхцөл гэж үзээд банкнаас үндэслэлгүй хөрөнгөжсөн мөнгөн хөрөнгийг гаргуулахаар гэж үзээд шийдвэрлэсэн байдаг. БНСУ-ын хувьд анх манай улсын адил шимтгэл авч байгаад хожим нь банк болон бусад зээл олгогч байгууллагууд шимтгэл авахаа зогсоосон байдаг.<sup>17</sup>” гэсэн байна.

### 1. Япон Улс

Япон Улсын зээлийн үйл ажиллагааны салбарт гэрээ байгуулах үед зээлийн шимтгэл суутгаж авах явдал нь нэгэнт тогтсон жишиг болсон байдаг<sup>18</sup>. Зээлийн шимтгэл суутгах нь хүчин төгөлдөр эсэх талаар Япон Улсын 1936 оны Дээд шүүхийн шийдвэр жишиг тогтоосон<sup>19</sup>. Маргааны үйл баримт нь дараах агуулгатай. Зээлдүүлэгч нь зээлдэгчид 15000 иений үндсэн зээл олгохоор харилцан тохиролцож мөнгөн зээлийн гэрээ байгуулсан. Түүнчлэн зээлдүүлэгч нь зээлийн шимтгэл (зээлийн судалгаа болон гэрээ байгуулах зардал)-ийг үндсэн зээлийн 12.6% буюу 1900 иенээр тооцон суутгаж, бодит байдал дээр 13100 иенийг зээлдэгчид олгосон байна. Зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй тул зээлдүүлэгч нь үндсэн зээл болох 15000 иен болон түүнд ноогдох хүүг зээлдэгчээс нэхэмжилсэн. Зээлдэгчийн зүгээс зээлийн шимтгэл тооцон авсан нь хууль бус бөгөөд үндсэн зээл нь 15000 иен бус зээлийн шимтгэлийг хассан дүн буюу 13100 иений хувьд байгуулагдсан гэж маргасан.

Дээд шүүх нь дараах тайлбарыг хийсний үндсэн дээр зээлийн шимтгэл суутгах явдлыг хүчин төгөлдөр байна гэж үзсэн. **Зээлийн гэрээ байгуулагдах үед зээлийн хүүгээс гадна зээлдэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр аливаа шимтгэлийг суутгаж авсан тохиолдолд, тухайн шимтгэл нь зээлдүүлэгчийн зүгээс зээлдэгчийн эд хөрөнгийн байдал болон бусад төрөл бүрийн нөхцөл**

<sup>16</sup> <https://datahelpdesk.worldbank.org/knowledgebase/articles/906519>, (Сүүлд үзсэн: 2022.10.16).

<sup>17</sup> <http://elbpartners.mn/post/57185>, (Сүүлд үзсэн: 2022.10.18).

<sup>18</sup> 金融商事法務研究会「金融取引における『利息』概念についての検討」3頁参照（2002年）。

<sup>19</sup> 大判昭和11年10月23日民集15巻21号1843頁; 金融取引の多様化を巡る法律問題研究会報告書「金融規制の適用範囲のあり方」8頁参照（2016年）。

**байдлыг судлан шинжлэх явдалд эсхүл гэрээ байгуулах үйл ажиллагаанд зарцуулсан цаг хугацаа, хүч хөдөлмөрийн хариу төлбөр гэдэг утгаар тухайн салбарын тогтсон жишгийн хувьд хэт өндөр биш байх хэмжээнд хүчин төгөлдөр байна.**

Дээрх Дээд шүүхийн шийдвэр нь зээлийн шимтгэлийг суутгаж авах явдлыг хүчин төгөлдөр гэж үзсэн төдийгүй үүний үндэслэлийг зээлдэгчийн эд хөрөнгийн байдал болон бусад төрөл бүрийн нөхцөл байдлыг судлан шинжлэх явдалд эсхүл гэрээ байгуулах үйл ажиллагаанд зарцуулсан цаг хугацаа, хүч хөдөлмөрийн **хариу төлбөр** гэж тайлбарласан<sup>20</sup>. Гэсэн хэдий ч бүхий л зээлийн шимтгэлийг хүчин төгөлдөр гэж үзээгүй бөгөөд тухайн зээлийн шимтгэл хүчин төгөлдөр байх хэмжээг **тухайн салбарын тогтсон жишгийн хувьд хэт өндөр биш байх хэмжээнд** хязгаарласан байна. Улмаар хэдий хэмжээний зээлийн шимтгэлийг хэт өндөр эсхүл хэт өндөр биш гэж үзэх вэ гэдэг асуудал үүсэх юм. Уг асуудлыг “Зээлийн хүүг хязгаарлах хууль”-иар зохицуулдаг.

“Зээлийн хүүг хязгаарлах хууль”<sup>21</sup> нь 1954 онд батлагдсан бөгөөд тус хуулийн зорилго нь бүхий л төрлийн мөнгөн зээлийн хүүгийн дээд хэмжээг хязгаарлах явдал юм. Тухайлбал зээлдүүлэгч нь эдийн засгийн хувьд харьцангуй давуу бус байдалд буй зээлдэгчид хэт өндөр зээлийн хүүг тулгах явдлаас сэргийлэх зорилготой<sup>22</sup>. Тус хууль нь дараах гол агуулгатай.

*Нэгдүгээр зүйл. Зээлийн гэрээний хүүг хязгаарлах*  
*Мөнгөн зээлийн гэрээний хүүгийн хувь хэмжээ нь доор дурдсан хувиас хэтэрсэн тохиолдолд хэтэрсэн хувь хэмжээний тухайд хүчингүй байна.*

- 1. Үндсэн зээлийн хэмжээ нь 100,000 иен хүртэлх тохиолдолд жилийн 20 хувь*
- 2. Үндсэн зээлийн хэмжээ нь 100,000 иенээс дээш 1 сая иенээс бага тохиолдолд жилийн 18 хувь*
- 3. Үндсэн зээлийн хэмжээ нь 1 сая иенээс их тохиолдолд жилийн 15 хувь*

*Хоёрдугаар зүйл. Зээлийн гэрээний хүүг урьдчилан суутган авсан тохиолдол (товчлов)*  
*Гуравдугаар зүйл. Зээлийн гэрээний хүү гэж тооцох*  
*Үндсэн зээлийн мөнгөнөөс гадна зээлдүүлэгчийн хүлээн авах аливаа мөнгийг талархлын мөнгө, хураамж, **шимтгэл**, төлбөр гэж нэрлэснээс үл хамааран **зээлийн гэрээний хүү гэж тооцно.***  
*Харин гэрээ байгуулах үеийн зардал болон зээлийн эргэн төлөлтийн зардалд энэ заалт хамаарахгүй.*

“Зээлийн хүүг хязгаарлах хууль”-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу зээлийн хүүгээс бусад аливаа төрлийн шимтгэл, хураамж, төлбөрүүд нь бүгд зээлийн гэрээний хүүгийн нэг хэсэг гэж тооцогдоно. Улмаар нэгдүгээр зүйлд заасан зээлийн хүүгийн дээд хэмжээний хязгаар нь гуравдугаар зүйлд заасан зээлийн гэрээний хүү гэж тооцогдох бүхий л төлбөрт нэгэн адил хамаарна. Өөрөөр хэлбэл дээд хязгаар нь жилийн 18 хувь байх тохиолдолд зээлийн гэрээний хүү болон зээлийн шимтгэлийн нийлбэр хувь нь үндсэн зээлийн 18 хувиас хэтэрсэн тохиолдолд хэтэрсэн хувь хэмжээ нь хүчингүй байна гэсэн агуулгатай.

Дээрхээс дүгнэж үзвэл, Япон Улсад “зээлийн шимтгэл”-ийг хүчин төгөлдөр гэж үздэг ба зээлийн хэмжээ, зээлийн хүү хоёр нь харилцан урвуу хамааралтайгаас гадна зээлийн шимтгэлийн хэмжээг зээлийн гэрээний хүүгийн нэг хэсэг гэж үзсэний үндсэн дээр

<sup>20</sup> 川島武宜「手数料控除と消費貸借」民事判例研究会『判例民事法 昭和 11 年度』473 頁参照（1936 年）。  
Мөн уг үндэслэлтэй холбоотойгоор дээрх Дээд шүүхийн шийдвэр нь “зээлийн шимтгэл нь зарцуулсан цаг хугацаа, хүч хөдөлмөрт л чиглэх бөгөөд зээлийн шимтгэлээс ашиг олж болохгүй” гэсэн зарчмыг дэвшүүлсэн байдаг.

<sup>21</sup> 利息制限法（昭和 29 年 5 月 15 日法律第 100 号）。

<sup>22</sup> 金融商事法務研究会「金融取引における『利息』概念についての検討」18 頁（2002 年）。

тэдгээрийн нийлбэрийн дээд хэмжээг хуулиар тогтоох замаар хязгаарлалт тавьж өгсөн байна.

## 2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ-д төрийн захиргааны байгууллагууд болон Хороонууд арилжааны банкны үйл ажиллагаанд хатуу хяналтыг тавьдаг<sup>23</sup>. Үүний хүрээнд 1995 онд Арилжааны банкны тухай хууль (Law of the People's Republic of China on Commercial Banks)<sup>24</sup> батлагдсан бөгөөд тус хууль арилжааны банкиг үүсгэн байгуулах, хадгаламж эзэмшигчдийн хамгаалалт, санхүү болон нягтлан бүртгэл, үйл ажиллагааны хяналт болон хууль зүйн хариуцлага гэх мэт суурь асуудлуудын тухай дэлгэрэнгүй зохицуулсан байдаг.

Тус хуулийн 4 дүгээр бүлэг (Зээл болон бусад үйл ажиллагааны суурь дүрмүүд)-ийн 50 дугаар зүйлд “Арилжааны банк бизнесийн үйл ажиллагаа явуулах болон үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох дүрэм, журмуудад заасны дагуу шимтгэл хураамжийг авна. Энэхүү шимтгэл хураамжийг авч болох банкны үйлчилгээ болон хувь хэмжээг Арилжааны банкны салбарыг зохицуулах төрийн байгууллага (China Banking and Insurance Regulatory Commission) болон БНХАУ-ын Төв банк нь өөрсдийн бүрэн эрхийн үндсэн дээр Үнийн бодлого хариуцсан хэлтэс (Department of Pricing under State Council)-тэй хамтран батална.” гэж тусгасан байна. Өөрөөр хэлбэл **БНХАУ-д зээлийн шимтгэл суутган авах явдлыг хүлээн зөвшөөрдөг** бөгөөд түүний хувь хэмжээг арилжааны банкны салбарыг зохицуулах төрийн байгууллага нь Үнийн бодлого хариуцсан хэлтэстэй хамтран холбогдох дүрэм журмаар зохицуулдаг байна.

Энэ үүднээс Арилжааны банкны салбарыг зохицуулах төрийн байгууллага буюу Арилжааны банк болон даатгалын салбарын зохицуулах хороо (China Banking and Insurance Regulatory Commission) нь 2014 онд “Арилжааны банкны үйлчилгээ үнийн бодлогыг зохицуулах журам”<sup>25</sup>-ыг баталсан байна. Тус журмын 1 дүгээр зүйлд журмын зорилгыг “арилжааны банкны үйлчилгээний үнийг тогтоох үйл ажиллагааг зохицуулах, харилцагчдын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, арилжааны банкны тогтвортой, аюулгүй хөгжлийг дэмжих явдал” гэж тодорхойлсон байна.

Мөн түүнчлэн тус журам арилжааны банкны үйлчилгээг дараах хоёр төрөлд хувааж холбогдох үнийн бодлогыг тогтоожээ. Үүнд:

<b>Төрийн хяналттай эсхүл төрөөс тогтоох үнэ бүхий үйлчилгээ (Government-administered or Government-fixed price)</b>	<b>Зах зээлийн тохируулгатай үнэ бүхий үйлчилгээ (market-adjusted price)</b>
Үндэсний эдийн засгийн хөгжил болон ард иргэдийн аж амьдралд нөлөө үзүүлэхүйц бүхий харилцагчдын хамгийн түгээмэл хэрэглэдэг суурь үйлчилгээ <sup>26</sup>	Төрийн хяналттай эсхүл төрөөс тогтоох үнэ бүхий үйлчилгээ (Government-administered or government-fixed price)-нээс бусад төрлийн үйлчилгээ

<sup>23</sup> 周劍龍「中国における商業銀行の法構造の現状と課題」獨協法学 92 号 330 頁、337 頁参照 (2013)。

<sup>24</sup> Тус хуулийн Англи хэл дээрх орчуулгыг [http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/12/content\\_1383716.htm-ээс](http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/12/content_1383716.htm-ээс) үзнэ үү.

<sup>25</sup> Тус журмын Англи хэл дээрх орчуулгыг <http://www.lawinfochina.com/display.aspx?id=16604&lib=law&EncodingName=big5-ээс> үзнэ үү.

<sup>26</sup> Эх сурвалж “**第八條.** 對客戶普遍使用、與國民經濟發展和人民生活關係重大的銀行基礎服務，實行政府指導價或政府定價。”

“**Article 8.** Basic banking services commonly used by clients and having a significant influence on national economic development and people's livelihood shall be subject to government-guided pricing or government-fixed pricing.” (орч.англ).

Дээрх хүснэгтээс үзвэл, харилцагчдын хамгийн түгээмэл ашигладаг арилжааны банкны үйлчилгээний үнийн тухайд Төр тодорхой хяналт болон удирдлага (Government adjusted price)-ыг хэрэгжүүлж байгаа бол түүнээс бусад төрлийн үйлчилгээ нь зах зээлийн тохируулгатай үнэ (market adjusted price)-ээр тогтох боломжтой байна. **Харилцагчдын хамгийн түгээмэл ашигладаг суурь үйлчилгээнд зээлийн үйлчилгээ (зээлийн эрсдэл хяналтын судалгаа шинжилгээ) хамаарахгүй учир зээлийн шимтгэлийн хувь хэмжээ зах зээлийн тохируулгатай үнэ (market adjusted price)-ээр тогтох боломжтой байна**<sup>27</sup>.

Түүнчлэн тус журмын 12 дүгээр зүйл нь Зах зээлийн тохируулгатай үнэ (market adjusted price) тогтоох эрхийг тухайн арилжааны банкны эсхүл салбарын удирдлагад олгосон байна.

Тус журмаас гадна 2022 онд Арилжааны банк болон даатгалын салбарыг зохицуулах хороо (Banking and Insurance Regulatory Commission)-ноос Зах зээлийн тохируулгатай үнэ (Market adjusted price)-ийг тогтооход баримтлах тайлбар (Guiding opinion)-ийг гаргасан<sup>28</sup>. Тус тайлбарт тусгаснаар зах зээлийн тохируулгатай үнэ (market adjusted price)-ийг “зүй зохистой, үндэслэлтэй, шинжлэх ухаанд тулгуурлан” тогтоох шаардлагатай. Тухайлбал: арилжааны банк нь зээлийн үйл ажиллагааг эрхлэхдээ бодитой үйлчилгээ (substantive service)-г үзүүлэхгүйгээр шимтгэл хураамж суутгаж авахыг хориглодог байна.

Иймд дүгнэж үзэхэд, БНХАУ-д зээлийн шимтгэл хурааж авах явдал нь хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд хувь хэмжээ нь зах зээлийн тохируулгатай үнэ (market-adjusted price)-ээр тогтдог байна. Мөн тухайн **зах зээлийн тохируулгатай үнэ нь “зүй зохистой, үндэслэлтэй, шинжлэх ухаанд тулгуурласан” байх бөгөөд ялангуяа бодитой үйлчилгээ (substantive service)-г үзүүлсэн байхыг шаарддаг байна.**

### 3. Бүгд Найрамдах Энэтхэг Улс

БНЭУ-д Банк болон банк бус санхүүгийн байгууллагыг бүрдүүлэх дүрэм, журмыг 1934 оны Энэтхэгийн Нөөцийн банкны тухай хуулийн (RBI Section 45 IA of RBI Act, 1934) 45 дугаар хэсгийн IA (1)-д заасны дагуу зохицуулдаг<sup>29</sup>.

Дээрх хуультай холбоотойгоор Энэтхэгийн бичил, жижиг, дунд үйлдвэрийн яамд харьяалагдах бичил, жижиг, дунд үйлдвэрийн газар (MSME) нь бизнесийн үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, хууль тогтоомжийг боловсруулах, удирдах дээд түвшний байгууллагад хамаардаг бөгөөд хэрэглэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд зориулсан зээл олгодог<sup>30</sup>.

Тус байгууллагын шийдвэрээр зээлийн хүү, шимтгэл болон бусад холбогдох зардлыг тогтоодгоос гадна түүний хяналтын дор бусад банкнууд үйл ажиллагаагаа явуулдаг. Энэхүү бичил, жижиг, дунд үйлдвэрийн байгууллагаас тогтоосон бизнесийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмын дагуу Энэтхэг Улсын “Төрийн банк” /State bank of India/-аас гаргасан банкны зээлийн үйл ажиллагаанд зээлийн хүүг жилийн 9.65 хувиар тогтоосон байх бөгөөд тухайн зээлдэгчийн үнийн дүнгээс хамааран **“Processing fee” буюу процессын**

<sup>27</sup> Тус журмын загвар болсон 2003 оны өмнөх журамд хамгийн түгээмэл ашиглагддаг үйлчилгээ гэдэгт Юанийн хадгаламж (deposit)-ийн суурь үйлчилгээнүүд багтаж байв. Тийм учраас зээлийн үйлчилгээг хамгийн түгээмэл ашиглагддаг суурь үйлчилгээ гэж үзэхгүй байх нь зүйтэй.

<sup>28</sup> Тус тайлбарын Англи хэл дээрх албан бус орчуулгыг <http://www.cbirc.gov.cn/cn/view/pages/governmentDetail.html?docId=1033935&itemId=861&generalType=1-ээс> үзнэ үү.

<sup>29</sup> <https://www.rbi.org.in/scripts/FS RTI Disclosure Logs.aspx?fn=14> (Сүүлд үзсэн: 2022.10.17).

<sup>30</sup> <https://msme.gov.in/about-us/about-us-ministry> (Сүүлд үзсэн: 2022.10.19).

**ШИМТГЭЛ** гэж зээлийн нийт үнийн дүнгээс 2 хувийг суутгаж авдаг байна<sup>31</sup>. Өөрөөр хэлбэл, БНЭУ-ын санхүүгийн зээлийн үйл ажиллагаанд шимтгэл, хураамжийг зохицуулж, тайлбарласан зохицуулалт байхгүй байх учир банкны үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан дээр дурдсан процессын шимтгэл авдаг болохыг тогтоолоо.

#### 4. Канад Улс

**Зээл олгох гарал үүслийн шимтгэл**<sup>32</sup>: Канад улсад зээлийн шимтгэлийг тухайн зээлдэгч ямарваа нэг шалтгаан үүссэнийг үл харгалзан төлбөрөө төлөх хугацаа хэтрүүлж, эсвэл зээлээ төлөөгүй тохиолдолд тодорхой хэмжээний торгуулийн хураамж авдаг. Үүнээс үүдэн зээлийн эцсийн зардалд тодорхой хэмжээний захиргааны хураамж ногдуулах боломжтой учраас үүнээс зээлийн гарал үүслийн шимтгэлийг тооцдог. Иймд зээлдэгчид зээл авах хүсэлтээ гаргасан тохиолдолд зээлдүүлэгчид зээлдэгчийн талаарх тодорхой хэмжээний судалгааг хийх шаардлага тулгардаг тул үүнтэй холбоотойгоор “захиргааны шимтгэл” хэмээн тооцож авдаг байна. Энэхүү “захиргааны шимтгэл” нь гарал үүслийн шимтгэл болон бүртгэлийн хураамжтай утга нэг ойлголт юм.

Тухайн зээлдүүлэгч хуулийн этгээд нь цөөн ажилтантай жижиг байгууллага эсэх, эсвэл том бүлэгтэй томоохон байгууллага эсэхийг үл хамааран тухайн зээлийн өргөдлийг боловсруулах (хүлээж авах) ажлыг нэг буюу хэд хэдэн ажилчдад даалгах шаардлага гардаг бөгөөд энэ нь нэлээдгүй цаг хугацаа, хүчин чармайлт шаарддаг. Улмаар өөр өөр зээлийн хэмжээ нь өөр хоорондоо ялгаатай түвшний эрсдэл болон үр өгөөжийг өгдөг учраас тухайн хүний болон санхүүгийн нөөцийг илүү их ашиглах, хүчин чармайлт гаргахад хүргэдэг. Иймээс олон төрлийн зээлийн төрөлд хамаарах “гарал үүслийн шимтгэл” буюу зарим тохиолдолд “зарцуулалт”-ийн шимтгэл гэж нэрлэдэг<sup>33</sup>-ийг авдаг.

Зээл олгох хураамж буюу зээлийн гарал үүслийн шимтгэлийг зээлдүүлэгч 1 удаа авах бөгөөд уг зээлийн гарал үүслийн тогтсон шимтгэл нь нийт зээлийн үнийн дүнгийн 0.5-аас 8 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүн байна. Ерөнхийдөө, зээлдэгч хэдий чинээ их мөнгө зээлэхийг хүснэ, зээлдүүлэгч тухайн зээлдэгчийн эрсдэлийн өсөх магадлалыг харгалзан үзэж, гарал үүслийн хураамжийг төдий чинээ өсгөдөг.

Зээлийн гарал үүслийн шимтгэлийг тооцохдоо, жишээ нь: Зээлдэгч 10,000 долларын зээл авах хүсэлт гаргаж, улмаар зээлдүүлэгч зээлийн үнийн дүнгийн 1%-ийн хураамж авдаг гэж бодъё. Зээлдэгч нийт зээлийн үлдэгдлээ аваад, анхны зээлийн эх үүсвэрээ уг хувь хэмжээгээр үржүүлнэ. ( $\$10,000 \times 0.01\% = \$100$ -ийн шимтгэл тооцно гэсэн үг). Харин зарим тохиолдолд зээлдэгч бага хугацааны зээл авах бол гарал үүслийн шимтгэлээс татгалзаж болдог<sup>34</sup>.

**Тухайн зээлийн гарал үүслийн шимтгэлийг төлүүлэх 2 арга байдаг.**

<b>Зээлээс суутгаж тооцох-</b> Зарим зээлдүүлэгчид зээлийн шимтгэлийг нийт зээлийн дүнгээс хасаж тооцдог. Жишээ нь: дээр дурдсанчлан, хэрэв зээлдэгч \$10,000 авахыг хүсэж байгаа, уг үнийн дүнгээс зээлийн шимтгэл гэж 1%-ийг хассанаар зээлдэгч \$9,900 авах	<b>Зээлээс тусад нь нэмэлт байдлаар тооцох-</b> Хэрэв зээлдэгч зээлийн үнийн дүнг бүтнээр авахыг хүсэж байгаа бол зээлдүүлэгч нар зээлийн нийт зардалд нэмэх байдлаар шимтгэлийг тооцон оруулж болно. Ингэснээр уг зээлийн төлбөрөөс шимтгэлийг салгаж тооцдог.
--	---

<sup>31</sup> <https://www.bankbazaar.com/personal-loan/msme-loan.html>, (Сүүлд үзсэн: 2022.10.19).

<sup>32</sup> <https://www.canada.ca/en/financial-consumer-agency/services/rights-responsibilities/rights-credit-loans.html> (Сүүлд үзсэн: 2022.10.16).

<sup>33</sup> <https://loanscanada.ca/loans/what-is-a-loan-origination-fee/> (Сүүлд үзсэн: 2022.10.16).

<sup>34</sup> <https://loanscanada.ca/loans/use-short-term-loan-tackle-emergency/>, (Сүүлд үзсэн: 2022.10.16).

хэдий ч зээлдүүлэгчид анх хүссэн зээлийн хэмжээ болох \$10,000-ийг буцаан төлнө гэсэн үг.	
---	--

Зээлдүүлэгч дараах алхмуудад зориулан “гарал үүслийн шимтгэл”-ийг суутгаж авдаг:

- Зээлийн баримт бичгийг бүрдүүлэх, боловсруулах;
- Орлого, санхүүгийн мэдээллийг шалгах;
- Зээлийн тайлан, амжилт, түүх, үнэлгээг шалгаж баталгаажуулах;
- Ипотекийн зээл эсвэл орон сууцны зээлийг дахин санхүүжүүлэх үнэлгээг удирдах;
- Эд хөрөнгийн хяналт шалгалт хийх (ипотекийн зээл эсвэл дахин санхүүжилтийн хувьд);
- Хоёрдогч эх сурвалжаас ипотекийн баримт бичиг, удирдамжийг авах хүсэлт (ипотекийн зуучлагчдад түгээмэл байдаг).

Мөн зээлдүүлэгч зээл үүссэний шимтгэлийг дараах 2 зээлийн төрөлд авдаг:

- Ипотекийн зээл;
- Их хэмжээний төлбөрт суурилсан зээл.

Канад Улсын Жижиг бизнесийн санхүүжилтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Бүртгэлийн хураамж” [Дүрмийн 4(1)] -ийг доорх байдлаар зохицуулсан байдаг.

<p><b>Бүртгэлийн хураамж нь:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Канад Улсын жижиг бизнесийн санхүүжилтийн зээлийн хувьд нийт дүнгийн 2%,</li> <li>• Канад Улсын жижиг бизнесийн санхүүжилтийн зээлийн шугамын хувьд бүртгэлийн хураамж нь зөвшөөрөгдсөн зээлийн үнийн дүнгийн 2%,</li> <li>• Шинэ бүртгэлийн маягт ирүүлж, шинэчилсэн зөвшөөрөгдсөн үнийн дүнгийн 2%-аар тогтоох ба бүртгэлийн хураамж төлсөн тохиолдолд зээлийн шугамыг нэмэлт 5 жилийн хугацаагаар сунгаж болно.</li> </ul> <p>Энэ хуульд зааснаар Канад Улсын инновац, шинжлэх ухаан, эдийн засгийн хөгжлийн сайд нь зээл олгох журмыг шийдвэрлэх, мөн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд байна<sup>35</sup>. Улмаар Канад Улсын жижиг бизнес эрхлэлтийн захиргаа (SBF Directorate) нь цахимаар бүртгүүлэх боломжийг олгож, тухайн зээлийн үйл явцад хяналт тавьдаг.</p>
---

## 5. Австралийн Холбооны Улс

Австрали болон Шинэ Зеландын нэгдсэн банк нь Австралийн Холбооны Улсын хоёр дахь том банк бөгөөд тус банкны бизнесийн зээлийн төрлүүд тус бүрд тооцох байдлаар зээлийн шимтгэлийг тодорхойлсон байна.

### Бизнесийн санхүүжилтийн хүрээнд авах шимтгэл

Австрали болон Шинэ Зеландын банк <sup>36</sup> (цаашид АБШЗ) нь бизнесийн санхүүжилтийн хүрээнд зээлийн зөвшөөрлийн шимтгэл эсвэл банкнаас тогтоосон дээд хязгаарын хэмжээгээр тооцоолон шимтгэл гэж авдаг. Эдгээр зээлийн шимтгэл авах зээлийн төрлүүдэд:

<sup>35</sup><https://ised-isde.canada.ca/site/canada-small-business-financing-program/en/find-loan-your-small-business/canada-small-business-financing-program-guidelines#10.1> (Сүүлд үзсэн: 2022.10.16).

<sup>36</sup><https://www.anz.com.au/content/dam/anzcomau/documents/pdf/business-banking-finance-fees-charges.pdf> (Сүүлд үзсэн: 2022.10.18).

- Бизнесийн богино хугацаат өр төлбөр буюу богино хугацаат зээл (overdraft<sup>37</sup>),
- Бизнесийн ашигтай богино хугацаат өр төлбөр буюу богино хугацаат зээл (advantage overdraft);
- Бизнесийн зээлийн кредит;
- Бизнесийн зээл\*;
- Бизнесийн ипотекийн зээл;
- Бизнесийн хэмнэлттэй зээл (saver loan);
- Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгийн зээл;
- Өртгийн санхүүжилт;
- Арилжааны төлбөр;
- Нөхөн төлбөр болон баталгаа;
- Эргэлтийн Agri Line<sup>38</sup>, мөн Agri санхүүжилт зэрэг зээлийн төрлүүд хамаардаг.

Уг зээлийн төрлүүдэд хамаарах шимтгэлийг зээлдэгч зээлийн хүсэлтээ гаргах үед нь АБШЗ-ийн банкнаас зээлийн зөвшөөрлийн шимтгэлийг тухайн бизнесийн зээлийн үнийн дүнд тулгуурлан тооцоолдог. Эдгээр тохиолдлуудад шимтгэлийн хэмжээг талуудын хоорондын хэлэлцээрийн дагуу тогтоох боломжтой<sup>39</sup>.

- Шинээр зээл авах эсвэл одоо байгаа зээлийн хэмжээг нэмэгдүүлэх тохиолдолд;
- Одоо байгаа зээлийг өөр зээлийн хэрэгсэлд шилжүүлэх тохиолдолд;
- Кредит зээлийн аюулгүй байдлыг хангах үүднээс (захиалагчийн хүсэлтээр);
- Кредит зээлийн хугацааг өөрчлөх эсвэл хувьсаж байгаа хэмжигдэхүүнийг тогтмол ханш руу шилжүүлэх, эсвэл эсрэгээр явагдах тохиолдлуудад шимтгэлийг тооцдог.

Компанийн нэр дээрх АБШЗ-ийн орон сууц худалдан авалтын зээл, болон орон сууцны хөрөнгө оруулалтын зээл, компанийн нэр дээрх хөрөнгийн менежмент болон компанийн нэр дээрх АБШЗ-ийн орон сууцны барьцаат зээлүүдэд тус тус зээлийн зөвшөөрлийн шимтгэл авдаг бөгөөд харин үүний дагуу шинэ зээл болон кредит зээл авахтай холбоотойгоор шимтгэл авдаггүй.

### Зээлийн үйлчилгээний хүрээнд авах шимтгэл

Зээлийн үйлчилгээний шимтгэлийг өөрөөр заагаагүй бол хугацаа хэтрүүлсэн тохиолдолд төлдөг. АБШЗ-ийн богино хугацаат зээл (overdraft), уг зээлийн үйлчилгээний шимтгэлийг банкнаас тогтоосон хязгаарын хэмжээгээр өдөр болгон тооцож авдаг бөгөөд дор дурдсан хураамжийг зээлдэгчийн данснаас шимтгэл болгон авна.

<sup>37</sup>2015 оны Монголбанкны “Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь”-д **Овердрафт /overdraft/** гэдэгт харилцагч тодорхой хязгаарын хүрээнд дансны үлдэгдлээсээ илүү хэмжээний мөнгө данснаасаа авсан үед бий болох богино хугацаат зээлийг хэлнэ гэжээ. 108 дахь тал. Харин **банкны овердрафт** гэдэгт “харилцагчийн өмнөөс банкны төлсөн мөнгөн хэмжээ нь “банкны овердрафт” гэсэн богино хугацаат өр төлбөр болно” гэсэн утга хамаарагдана. Банкны овердрафт нь нэг төрлийн банкны зээлийн үйлчилгээ бөгөөд хүүтэй, хүүгүй байж болно. 68 дахь тал. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/GLOSSARY.pdf>

<sup>38</sup> Revolving Agri Line гэдэгт хөдөө аж ахуйн бизнест тусгайлан зориулсан уян хатан зээлийн шугамаар мөнгөн гүйлгээний хэлбэлзлийг удирддаг зээлийн төрөлд ордог. Энэ зээл нь хамгийн багадаа 250,000 долларыг олгодог болно. <https://www.anz.com.au/business/loans-finance/revolving-agri-line/#:~:text=Manage%20cashflow%20fluctuations%20with%20a,Fee%20and%20an%20approval%20fee> (Сүүлд үзсэн: 2022.10.19).

<sup>39</sup> Мөн тэнд, Эшлэл 56. 2 дахь тал, (Сүүлд үзсэн: 2022.10.18).

- Зээлдэгчийн зээлийн данс нээлгэсэн өдрийг харгалзан үзэж хугацаа хэтрүүлсэн өр төлбөр болон зээлийн хязгаарлалтад өөрчлөлт орсон эсэхийг авч үзэж улирал тутам хувь тэнцүүлсэн байдлаар:
  - ✓ \$9,999 буюу түүнээс бага үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд \$250-ийн шимтгэл суутгах;
  - ✓ \$10,000-аас \$19,999 хүртэлх үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд \$400-ийн шимтгэл суутгах;
  - ✓ \$20,000-аас \$49,999 хүртэлх үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд \$600-ийн шимтгэл суутгах;
  - ✓ \$50,000-аас \$499,999 хүртэлх үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд 1.7%-иар тооцож шимтгэл суутгах;
  - ✓ \$500,000-ийн хязгаар эсхүл түүнээс дээш үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд өргөдлийн үнийн дүнгийн хүрээнд шимтгэлийг тооцно.
- АБШЗ-ийн банк нь талууд хоорондын тохиролцсон арилжааны зээлд шимтгэл авдаггүй.

**АБШЗ-ийн бизнесийн ашигтай богино хугацааны зээлийн хүрээнд авах шимтгэл (overdraft)<sup>40</sup>**

АБШЗ-ийн бизнесийн ашигтай богино хугацааны зээл (overdraft)- Уг зээлийн үйлчилгээний шимтгэлийг банкнаас тогтоосон хязгаарын хэмжээгээр өдөр болгон тооцож авдаг бөгөөд дор дурдсан хураамжийг зээлдэгчийн данснаас шимтгэл болгон авна.

- Зээлдэгчийн зээлийн данс нээлгэсэн өдрийг харгалзан үзэж хугацаа хэтрүүлсэн өр төлбөр болон зээлийн хязгаарлалтад өөрчлөлт орсон эсэхийг авч үзэж улирал тутам хувь тэнцүүлсэн байдлаар:
  - ✓ \$9,999 буюу түүнээс бага үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд \$250-ийн шимтгэл тооцох;
  - ✓ \$10,000-аас \$19,999 хүртэлх үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд \$400-ийн шимтгэл тооцох;
  - ✓ \$20,000-аас \$49,999 хүртэлх үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд \$600-ийн шимтгэл тооцох;
  - ✓ \$50,000-ийн хязгаар болон түүнээс дээш үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд 1.7%-иар тооцож шимтгэл суутгах.

**АБШЗ-ийн хувьсах Agri Line<sup>41</sup>**- Уг зээлийн үйлчилгээний шимтгэлийг банкнаас тогтоосон хязгаарын хэмжээгээр өдөр болгон тооцож авдаг бөгөөд дор дурдсан хураамжийг зээлдэгчийн данснаас шимтгэл болгон авна. Үүнд:

- Зээлдэгчийн зээлийн данс нээлгэсэн өдрийг харгалзан үзэж хугацаа хэтрүүлсэн өр төлбөр болон зээлийн хязгаарлалтад өөрчлөлт орсон эсэхийг авч үзэж улирал тутам хувь тэнцүүлсэн байдлаар:
  - ✓ \$250,000 буюу түүнээс дээш үнийн дүнтэй зээл авсан тохиолдолд уг зээлийн хязгаарын төлбөрт 0.5%-ийн шимтгэл авдаг.

**АБШЗ-ийн бизнесийн кредит зээл**

Үйлчилгээний шимтгэлийг зээлийн үнийн дүнд үндэслэн зээлийн данснаас суутган тооцож авна.

<sup>40</sup> Мөн тэнд. Эшлэл 56. 4 дэх тал. (Сүүлд үзсэн: 2022.10.18).

<sup>41</sup> Мөн тэнд. Эшлэл 56. 5 дахь тал. (Сүүлд үзсэн: 2022.10.18).

- Зээлдэгчийн зээлийн данс нээлгэсэн өдрийг харгалзан үзэж хугацаа хэтрүүлсэн өр төлбөр болон зээлийн хязгаарлалтад өөрчлөлт орсон эсэхийг авч үзэж сар тутам хувь тэнцүүлсэн байдлаар \$600-ийн шимтгэл тооцож авдаг.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээгээр “зээлийн шимтгэл” авах боломжтой эсэх, энэ нь үндэслэлтэй, хууль ёсны эсэхийг тогтоох зорилгоор Монгол Улс болон гадаадын зарим орны “зээлийн шимтгэл”-ийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт, *шүүхийн практикийг* судлаад дараах дүгнэлтийг хийж байна:

1. Банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээний “зээлийн шимтгэл”-ийг авах эрх зүйн үндэслэлийг анх Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/236 дугаартай “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-аар зохицуулж байсан. Энэ журамд 2015 онд өөрчлөлт оруулсны зэрэгцээ тус журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/203 дугаартай “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг шинэчлэн батлахад хүчингүй болгожээ.
2. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д “зээлийн шимтгэл” 1 хувь байхаар зохицуулсантай холбогдуулан тухайн цаг үеэс хойш буюу 2008 оноос хойш 2013 оны Монголбанкны Ерөнхийлөгчийн А/236 дугаар журам батлагдан, ипотекийн зээлийн харилцаатай төстэй байдлаар банк, эрх бүхий этгээдээс олгох зээлийн гэрээндээ “зээлийн шимтгэл”-ийг 1 хувиар төстэй байдлаар тооцон авах болсон байна.
3. 1995 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд “зээлийн шимтгэл”-тэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан хуульчлаагүй байсан бол 2021 оны Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгад “шимтгэл”-тэй холбоотойгоор “*банк харилцагчаас зөвхөн гэрээнд заасан хэмжээгээр төлүүлэх эрхтэй*”-ээр хуульчилжээ. Мөн 2021 онд батлагдсан хуулийн “зээлийн шимтгэл”-д холбогдох онцлог зохицуулалтын нэг нь Монголбанкнаас хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд арилжааны банкныг шимтгэлийн хувь хэмжээгээ хэт өндрөөр тогтоосон тохиолдолд бууруулахыг санал болгох, тухайн саналыг хүлээж аваагүй тохиолдолд арилжааны банкны “шимтгэлийн хувь хэмжээ тогтоосон шийдвэр”-ийг хүчингүй болгох эрхтэй байхаар заасан явдал юм.
4. Харьцуулсан судалгааны хүрээнд сонгон авч судалсан орнууд зээлийн шимтгэлийг суутган авах явдлыг хуульд нийцсэн хүчин төгөлдөр буюу “зээлийн шимтгэл авахыг хүлээн зөвшөөрдөг” боловч тухайн зээлийн шимтгэлийг зарчмын хувьд үйл ажиллагаанд гарсан бодит зардалтай тэнцэхүйц, түүнд чиглэсэн байхыг шаарддаг байна. Харин зээлийн шимтгэлийн хүрээ хязгаарыг хууль зүйн хувьд зохицуулах, түүний дээд хязгаарыг хуульчлах төрөл бүрийн хууль тогтоох техникийг ашигласан байдал ажиглагдаж байна. Тухайлбал Япон Улсад зээлийн хүү, зээлийн шимтгэл, хураамжийн нийлбэрийн дээд хувь хэмжээг “Зээлийн хүүг хязгаарлах хууль”-иар тогтоож өгсөн байх бөгөөд тухайн хуульд заасан хувиас хэтэрсэн аливаа зээлийн хүү, шимтгэл, хураамж нь анхнаасаа хүчин төгөлдөр бус байна. Харин БНХАУ-д зээлийн үйлчилгээ тухайлбал зээлийн шимтгэл нь холбогдох журамд заасны дагуу зах зээлийн тохируулгатай үнэ (market-adjusted price)-ээр тогтоодог байна. Зах зээлийн тохируулгатай үнэ (market-adjusted price)-ийг арилжааны банкны удирдлага бие даан тогтоох боломжтой боловч тухайн үнэ нь “зүй зохистой, үндэслэлтэй,

шинжлэх ухаанд тулгуурласан” байх шаардлагатай. Ялангуяа бодит үйлчилгээ (substantive service)-г үзүүлэхгүйгээр шимтгэл суутган авахыг хориглодог.

5. БНЭУ-д “зээлийн хураамж”, “зээлийн шимтгэл”-ыг ялгамжтайгаар зохицуулаагүй, зээлийн шимтгэлд зээлийн үнийн дүнгийн тодорхой хувийг буюу 2 хувийг суутган авдаг бол Канад Улсад зээлийн шимтгэлийн хувь хэмжээг зээлийн үнийн дүн, зээлийн эрсдэл болон зээлийн төрлөөс хамааран холбогдох дүрэм журмуудаар нарийвчлан тогтоодог, Австралийн Холбооны Улсын хувьд зээлийн шимтгэлийн дээд хэмжээг тодорхой төрлийн зээлүүдэд хуульчилж өгсөн онцлогтой байна.

## ЭХ СУРВАЛЖ

### Ном, сурах бичиг, гарын авлага:

1. Б.Буянхишиг, Үүргийн эрх зүйн ерөнхий анги, 2021 он.
2. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2021 он.
3. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2021 он.
4. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021 он.
5. Монголбанкнаас гаргасан “Зээл” гарын авлага.  
<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/07.pdf>
6. Ё.Кают, Иргэний хуулийн тайлбар.

### Гарын авлага, тайлан мэдээ, хууль тайлбарласан тогтоол:

1. Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн батлах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн А-105 дугаар тушаал, 2021 он.  
<https://www.mongolbank.mn/documents/regulation/2021/A-105%20DSIB%20list.pdf>
2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 446 тоот тушаалын нэгдүгээр хавсралт.  
<https://www.mongolbank.mn/documents/regulation/money/bankipotek.pdf>
3. Монголбанкны цахим хуудас,  
[https://www.mongolbank.mn/documents/regulation/20150512\\_A85.pdf](https://www.mongolbank.mn/documents/regulation/20150512_A85.pdf)
4. Улсын дээд шүүхийн 2010 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоол.
5. УДШ-ийн Практик судалгааны хэлтсээс ШССМХ-д ирүүлсэн материал.

### Гадаад эх сурвалж:

1. 金融商事法務研究会「金融取引における『利息』概念についての検討」3頁参照（2002年）。
2. 大判昭和11年10月23日民集15巻21号1843頁；金融取引の多様化を巡る法律問題研究会報告書「金融規制の適用範囲のあり方」8頁参照（2016年）。
3. 川島武宜「手数料控除と消費貸借」民事判例研究会『判例民事法 昭和11年度』473頁参照（1936年）。
4. 利息制限法（昭和29年5月15日法律第100号）。
5. 金融商事法務研究会「金融取引における『利息』概念についての検討」18頁（2002年）。
6. 周劍龍「中国における商業銀行の法構造の現状と課題」獨協法学92号330頁、337頁参照（2013）。

### Цахим эх сурвалж:

1. Шүүхийн шийдвэрийн цахим сан, <https://shuukh.mn/>
2. “第八條. 對客戶普遍使用、與國民經濟發展和人民生活關係重大的銀行基礎服務，實行政府指導價或政府定價。 “Article 8. Basic banking services commonly used by clients and having a significant influence on national economic development and people's livelihood shall be subject to government-guided pricing or government-fixed pricing.”  
<http://www.cbirc.gov.cn/cn/view/pages/governmentDetail.html?docId=1033935&itemId=861&generalType=1>
3. <https://www.canada.ca/en/financial-consumer-agency/services/rights-responsibilities/rights-credit-loans.html>

4. <https://loanscanada.ca/loans/what-is-a-loan-origination-fee/>
5. <https://loanscanada.ca/loans/use-short-term-loan-tackle-emergency/>
6. <https://ised-isde.canada.ca/site/canada-small-business-financing-program/en/find-loan-your-small-business/canada-small-business-financing-program-guidelines#>
7. <https://www.anz.com.au/content/dam/anzcomau/documents/pdf/business-banking-finance-fees-charges.pdf>
8. <https://www.anz.com.au/business/loans-finance/revolving-agri-line/#:~:text=Manage%20cashflow%20fluctuations%20with%20a,Fee%20and%20an%20approval%20fee>
9. [http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/12/content\\_1383716.htm](http://www.npc.gov.cn/zgrdw/englishnpc/Law/2007-12/12/content_1383716.htm)
10. <http://www.lawinfochina.com/display.aspx?id=16604&lib=law&EncodingName=big5>  
<http://elbpartners.mn/post/571>